



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 8/237

Улаанбаатар хот

**Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн
орлогыг зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны хуулийн 31 зүйлийн 31.6, 31.7, 31.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1532 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1.Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2025 онд нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн мөнгөн төлбөрийн орлогын хувийг батлагдсан хууль, тогтоомж дүрэм журмын хүрээнд Цэргийн штабын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэх, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Батлан хамгаалах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдахаар зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

2.Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр худалдан авах эд хэрэгслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Мөнгөн төлбөрийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т, бараа материалыг Тамгын газрын орлого, данс бүртгэлд авахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү), Аж ахуйн тасгийн эрхлэгч, нярав (П.Дэлгэр) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 14-ны өдрийн 4287 дугаар
захирамжийн хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ МӨНГӨН ТӨЛБӨРӨӨР
ХУДАЛДАН АВАХ ЭД ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТАД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/д	Худалдан авах шаардлагатай бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Зөөврийн компьютер	2	2,500,000	5,000,000
2	Ухаалаг дэлгэц	1	5,500,000	5,500,000
3	Машины урсгал засвар	-	1,200,000	1,200,000
4	Цэргийн бүртгэлийн мэдээллийн сан, эрүүлжүүлэлтийн программыг шинэчлэх	2	1,500,000	3,000,000
5	Гар станц	5	100,000	500,000
6	Баримт бичгийн шүүгээ (шкаф)	-	-	800,000
	Нийт			16,000,000

